



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО


**БИЧИЛ УУРХАЙ
ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ
НЭГДСЭН ТАЙЛАН
2021**

Улаанбаатар хот
2022 он



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН 2021 ОН



Улаанбаатар хот
2022 он

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Б.Батдаваа	Дарга
Д.Лхамсүрэн	Дэд дарга
Б.Саранчимэг	Нэгдсэн статистикийн газрын дарга
Ц.Тэгшжаргал	Эдийн засгийн статистикийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (ЭЗСГ)
Э.Мягмарханд	ЭЗСГ-ын Хөдөө аж ахуй, байгаль орчин үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга (ХААБОҮСХ)

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

Б.Уянгаа	ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн ахлах статистикч
Ч.Ууганбаяр	ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн статистикч
Б.Лхагвасайхан	ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн статистикч
Л.Шинэтуяа	ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн статистикч
Б.Энхболд	ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44
Засгийн газрын III байр
Утас: (976-51)-261565, 1900-1212
Факс: (976-11)-324518
Цахим хуудас: <http://nso.mn>, www.1212.mn
И-мэйл: information@nso.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	vii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	ix
ӨМНӨХ ҮГ	x
I. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	1
I.1 СУДАЛГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	2
I.2 СУРГАЛТ.....	2
I.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА	2
I.4 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	4
I.5 СУДАЛГААНЫ АСУУЛГА, ТҮҮНИЙ АГУУЛГА.....	4
I.6 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	5
II. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	10
II.1 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД.....	7
II.2 БИЧИЛ УУРХАЙН ОРД ГАЗРЫН ТОО.....	9
II.3 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖЭЭР	11
II.4 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ	12
II.5 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН.....	13
II.6 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ МЭРГЭЖИЛ	14
II.7 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АМ БҮЛИЙН ТОО.....	16
III. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ.....	10
III.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ	18
III.2 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХУГАЦАА, ШАЛТГААН.....	20
III.3 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, УНДНЫ УС.....	22
IV. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ, МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ .	30
IV.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ	28
IV.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА	28
V. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЛЭГ	36

V.1	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЛЭГ	33
V.2	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛДВЭРИЙН ОСОЛ АВААР, ӨВЧНИЙ ТӨРӨЛ	33
VI.	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	38
VI.1	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА АШИГЛАЖ БУЙ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ.....	38
VI.2	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС	40
VII.	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	48
VII.1	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	44
VII.2	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТАЛБАЙ.....	45
VII.3	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО, ЗАРДАЛ	51
VII.4	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЛЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 57	
VIII.	ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ, ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ	48
VIII.1	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ АВСАН БАЙДАЛ.....	61
VIII.2	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ.....	62
VIII.3	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ	66
VIII.4	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АМЬЖИРГААНЫ ӨӨРЧЛӨЛТ	66
VIII.5	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР.....	67
IX.	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ	76
IX.1	БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ.....	70
IX.2	БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 18-ААС ДООШ НАСНЫ ХҮҮХДИЙН ОРОЛЦОО ХАВСРАЛТ ХҮСНЭГТ	71 72

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, бүсээр	7
ХҮСНЭГТ 2. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, бүсээр, хүйсээр	8
ХҮСНЭГТ 3. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, аймаг, нийслэл, засаг захиргааны харьяаллаар	11
ХҮСНЭГТ 4. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, насны бүлгээр, хүйсээр	12
ХҮСНЭГТ 5. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бүс, насны бүлгээр	12
ХҮСНЭГТ 6. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, бүсээр	13
ХҮСНЭГТ 7. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, хүйсээр, дүнд эзлэх хувиар	14
ХҮСНЭГТ 8. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ажил мэргэжлээр, хүйсээр.....	15
ХҮСНЭГТ 9. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бүс, ажил мэргэжлээр	15
ХҮСНЭГТ 10. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, бүсээр	19
ХҮСНЭГТ 11. НӨХӨРЛӨЛ, ХОРШОО, ГИШҮҮДИЙН ТОО, хүйсээр.....	20
ХҮСНЭГТ 12. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бичил уурхай эрхэлж буй шалтгаанаар, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар	21
ХҮСНЭГТ 13. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, бүсээр, хувиар	23
ХҮСНЭГТ 14. БИЧИЛ УУРХАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, олборлодог ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар	24
ХҮСНЭГТ 15. БИЧИЛ УУРХАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, бүсээр, дүнд эзлэх хувиар	25
ХҮСНЭГТ 16. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, олборлодог ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар	25
ХҮСНЭГТ 17. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ, давхардсан тоогоор, бүсээр, дүнд эзлэх хувиар	29
ХҮСНЭГТ 18. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ, давхардсан тоогоор, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар	30
ХҮСНЭГТ 19. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ, давхардсан тоогоор, ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар	30
ХҮСНЭГТ 20. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, бүсээр, дүнд эзлэх хувиар	33
ХҮСНЭГТ 21. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛ, төрлөөр, ажилласан хугацаагаар, дүнд эзлэх хувиар	35
ХҮСНЭГТ 22. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛТ, өвчний төрлөөр, бүсээр, дүнд эзлэх хувиар	35

ХҮСНЭГТ 23.. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ СУМ, ДҮҮРГИЙН ЭМНЭЛГИЙН ЗАЙ, километрээр	36
ХҮСНЭГТ 24.. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, судалгаа явагдсан оноор.....	38
ХҮСНЭГТ 25.. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ашигт малтмалын төрлөөр, давхардсан тоогоор	39
ХҮСНЭГТ 26. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, төрлөөр, бүсээр, дүнд эзлэх хувиар	40
ХҮСНЭГТ 27. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, хүйсээр	40
ХҮСНЭГТ 28. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, насны бүлгээр	41
ХҮСНЭГТ 29. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ХЭРЭГЛЭДЭГ ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, төрлөөр, бүсээр, хувиар	42
ХҮСНЭГТ 30. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ашигт малтмалын төрлөөр, бүсээр	44
ХҮСНЭГТ 31. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, орд газар, ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар	44
ХҮСНЭГТ 32. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ашиглаж буй талбайн төрлөөр, бүсээр.....	45
ХҮСНЭГТ 33. ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД АЖИЛЛАЖ БАЙГАА БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ашигт малтмалын төрөл, ашиглаж байгаа талбайн төрлөөр, давхардсан тоогоор.....	45
ХҮСНЭГТ 34. БИЧИЛ УУРХАЙД АШИГЛАЖ БУЙ ТАЛБАЙ, НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, бүсээр	46
ХҮСНЭГТ 35. БОРЛУУЛСАН АШИГТ МАЛТМАЛЫН ХЭМЖЭЭ, ашигт малтмалын төрлөөр.....	47
ХҮСНЭГТ 36. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ОЛБОРЛОСОН АШИГТ МАЛТМАЛАА БОРЛУУЛДАГ НЭГЖ, бүсээр, дүнд эзлэх хувиар.....	47
ХҮСНЭГТ 37. АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ТОО, ОЛБОРЛОСОН АЛТНЫ ХЭМЖЭЭ, ДУНДАЖ ҮНЭ, бүсээр	48
ХҮСНЭГТ 38. НҮҮРС ОЛБОРЛОГЧДЫН ТОО, ОЛБОРЛОСОН ХЭМЖЭЭ, ДУНДАЖ ҮНЭ, аймаг, нийслэлээр.....	49
ХҮСНЭГТ 39. ЖОНШ ОЛБОРЛОГЧДЫН ТОО, ОЛБОРЛОСОН ХЭМЖЭЭ, ДУНДАЖ ҮНЭ, аймгаар	49
ХҮСНЭГТ 40. ГЯНТБОЛД ОЛБОРЛОГЧДЫН ТОО, ОЛБОРЛОСОН ГЯНТБОЛДЫН ХЭМЖЭЭ, ДУНДАЖ ҮНЭ, аймгаар.....	50
ХҮСНЭГТ 41. БУСАД ТӨРЛИЙН АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧДЫН ТОО, аймгаар, дүнд эзлэх хувиар	50
ХҮСНЭГТ 42. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО, бүсээр.....	51
ХҮСНЭГТ 43. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ, сая төгрөг, зардлын төрөл, ашигт малтмалын төрлөөр	52
ХҮСНЭГТ 44. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ, зардлын төрөл, бүсээр	53
ХҮСНЭГТ 45. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бүс, татвар төлсөн эсэхээр	54

ХҮСНЭГТ 46. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТӨЛСӨН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ, бүс, зардлын төрлөөр, сая төгрөг	54
ХҮСНЭГТ 47. НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүсээр, сая төгрөг	55
ХҮСНЭГТ 48. НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүрэлдэхүүн хэсгээр, бүсээр, сая төгрөг	56
ХҮСНЭГТ 49. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, бүрэлдэхүүн хэсэг, бүсээр, сая төгрөг	57
ХҮСНЭГТ 50. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ, хөрөнгийн төрөл, бүсээр, сая төгрөгөөр	58
ХҮСНЭГТ 51. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН 2021 ОНД ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ, ашигт малтмалын төрөл, хөрөнгийн төрлөөр, сая төгрөг	59
ХҮСНЭГТ 52. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ АВСАН БАЙДАЛ, бүсээр	61
ХҮСНЭГТ 53. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ, бүсээр, төрлөөр, дүнд эзлэх хувиар	62
ХҮСНЭГТ 54. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүсээр, давхардсан тоогоор	62
ХҮСНЭГТ 55. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН ГАЗРЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ, ашигт малтмалын төрлөөр, хувиар.....	65
ХҮСНЭГТ 56. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН 2021 ОНД ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, бүсээр	66
ХҮСНЭГТ 57. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АМЬЖИРГААНЫ ӨӨРЧЛӨЛТ, бүсээр, дүнд эзлэх хувиар	67
ХҮСНЭГТ 58. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР, бүсээр, дүнд эзлэх хувиар	68
ХҮСНЭГТ 59. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийн түвшнээр, бүсээр.....	70
ХҮСНЭГТ 60. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮҮХДИЙН ОРОЛЦОО, хувиар, бүсээр	71
ХҮСНЭГТ 61. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО, бүсээр, бэртэл гэмтлийн төрлөөр, дүнд эзлэх хувиар.....	72

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, аймаг, нийслэлээр, бичил уурхай эрхлэгчдийн тооны бүлгээр.....	9
ЗУРАГ 2. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, ОРД ГАЗРЫН ТОО, аймгаар	9
ЗУРАГ 3. НЭГЖ ОРД ГАЗАРТ НОГДОХ БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, аймгаар	10
ЗУРАГ 4. БИЧИЛ УУРХАЙД АШИГЛАГДАЖ БУЙ ОРД ГАЗРЫН ТОО, аймаг, нийслэлээр, ашигт малтмалын төрлөөр.....	10
ЗУРАГ 5. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙГ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА	13
ЗУРАГ 6. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АМ БҮЛИЙН ТОО, судалгаа явагдсан оноор, дүнд эзлэх хувиар.....	16
ЗУРАГ 7. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ажил эрхлэлтийн байдлаар	18
ЗУРАГ 8. НӨХӨРЛӨЛ, ХОРШООНЫ ГИШҮҮДИЙН ТОО, аймгаар	19
ЗУРАГ 9. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бичил уурхайд ажилласан жилээр, дүнд эзлэх хувиар	20
ЗУРАГ 10. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бичил уурхай эрхэлж буй шалтгаанаар, дүнд эзлэх хувиар.....	21
ЗУРАГ 11. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, эзэмшлийн хэлбэрээр	22
ЗУРАГ 12. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, төрлөөр, дүнд эзлэх хувиар	23
ЗУРАГ 13. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, утасны төрлөөр, дүнд эзлэх хувиар	28
ЗУРАГ 14. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ХАМГИЙН ИХ ХЭРЭГЦЭЭТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар	29
ЗУРАГ 15. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨРТӨЖ БАЙСАН ОСОЛ, АВААРЫН ТӨРӨЛ, дүнд эзлэх хувиар.....	33
ЗУРАГ 16. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДЭД УЧИРСАН ХОХИРЛЫН ТӨРӨЛ, дүнд эзлэх хувиар	34
ЗУРАГ 17. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛТ, өвчний төрлөөр, дүнд эзлэх хувиар	34
ЗУРАГ 18. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, эзэмшлийн төрлөөр, дүнд эзлэх хувиар.....	38
ЗУРАГ 19. ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭДЭГ БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, боловсролын түвшингээр, дүнд эзлэх хувиар.....	41
ЗУРАГ 20. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭДЭГ ЭСЭХ, ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар	42
ЗУРАГ 21. АШИГЛАСАН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, судалгаа явагдсан оноор.....	46

ЗУРАГ 22. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН БОРЛУУЛСАН НЭГ ГРАММ АЛТНЫ ДУНДАЖ ҮНЭ, аймгаар, мянган төгрөгөөр.....	48
ЗУРАГ 23. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО, аймгаар, сая төгрөгөөр	52
ЗУРАГ 24. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТАТВАР ТӨЛӨЛТ, ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар	55
ЗУРАГ 25. 2021 ОНД ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, бүсээр, дүнд эзлэх хувиар.....	58
ЗУРАГ 26. ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ, төрлөөр, хувиар	61
ЗУРАГ 27. ОРОН НУТГИЙН ЗАСАГ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХАД ХҮНДРЭЛТЭЙ БАЙДАГ АСУУДАЛ, төрлөөр, хувиар.....	63
ЗУРАГ 28. АШИГТ МАЛТМАЛ БОРЛУУЛАХАД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, ашигт малтмалын төрлөөр, давхардсан тоогоор.....	64
ЗУРАГ 29. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС АВАХЫГ ХҮСЭЖ БУЙ ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ, төрлөөр, дүнд эзлэх хувиар	65
ЗУРАГ 30. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, амьжиргаанд өөрчлөлт орсон төрлөөр, дүнд эзлэх хувиар.....	66
ЗУРАГ 31. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР.....	67
ЗУРАГ 32. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР, хувиар, ашигт малтмалын төрлөөр.....	68
ЗУРАГ 33. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО, хувиар.....	70
ЗУРАГ 34. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО, ажиллаж буй хугацааны төрлөөр, дүнд эзлэх хувиар.....	71

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БУЭ	Бичил уурхай эрхлэгч
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
МТГ	Мэдээллийн технологийн газар
НСГ	Нэгдсэн статистикийн газар
СЯ	Сангийн яам
ТБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
ТЕГ	Татварын ерөнхий газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХААБОҮСХ	Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтэс
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж, үйлчилгээний ерөнхий газар
ЭМНДЕГ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар
ЭЗСГ	Эдийн засгийн статистикийн газар

ӨМНӨХ ҮГ



Үндэсний Статистикийн Хороо нь дэлхийн улс орнуудын статистикийн байгууллагуудын нэгэн адил улс орны эдийн засаг дахь албан бус секторын үйл ажиллагааны үр дүнг дотоодын нийт бүтээгдэхүүнд тусгах талаар тодорхой ажлуудыг үе шаттайгаар авч хэрэгжүүлж ирсэн.

ҮСХ-ны даргын 2017 оны 12 сарын 26-ны өдрийн 219-р тушаалаар батлагдсан “Дотоодын нийт бүтээгдэхүүн тооцох аргачлал”-ын далд эдийн засгийн тооцооны албан бус секторын үйлдвэрлэлийн тооцоох арга зүй хэсэгт албан бус салбарын суурь судалгааг 5 жил тутам явуулна, уул уурхайн салбарын хувьд тусгайлсан судалгааны хэлбэрээр явуулна гэж заасан байдаг. Энэхүү аргачлалын хүрээнд уул уурхайн салбарт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн судалгааг 3 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

Энэ удаагийн судалгааны зорилго нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй нэгжүүдийн тоо, хамрах хүрээг тогтоон, бүртгэлжүүлэх, тэдгээрийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлж, ДНБ-ий тооцоонд тусгах, үйл ажиллагаа эрхлэгчдийн өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлон төрийн болон төрийн бус байгууллагуудыг мэдээллээр хангах, өмнөх судалгааны мэдээллийг шинэчлэх, харьцуулалт хийх, шаардлагатай нэмэлт мэдээллийг бий болгоход чиглэгдсэн.

Судалгааны үр дүн нь манай улсын эдийн засагт голлох байр эзэлдэг уул уурхай, олборлох салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өнөөгийн дүр төрхийг тодорхойлоход шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлснээрээ онцлог юм.


Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч 3.4 мянган иргэд тус судалгаанд хамрагдсан бөгөөд ашигт малтмал олборлож буй иргэдийн дийлэнх нь буюу 82.5 хувь нь алт олборлож байна. Түүнчлэн ашигт малтмал олборлож буй иргэдийн орлогын 75.4 хувь, нэмэгдэл өртгийн 83.0 хувийг алт олборлолтын үйл ажиллагаанаас бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газар бичил уурхайн салбарыг төрөөс зохицуулах, энэ салбарыг үндэсний эдийн засгийг бүрдүүлэгч идэвхтэй хэсэг болгох талаар явуулж буй арга хэмжээний хүрээнд бичил уурхайд чиглэсэн бодлого эрх зүйн таатай орчныг бий болгох, албан ёсны, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг дэмжих, бүртгэлжүүлэх үүднээс “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоол, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоол зэргийг шинэчлэн баталсан. Журам шинэчлэгдэн батлагдсанаар бичил уурхай үйл ажиллагааг бүртгэлжүүлэх, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах, ингэснээр албан ёсоор үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайчдын тоо нэмэгдэх зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч байна.

Үр дүнгийн тайлан үндсэн 9 бүлэг танилцуулга болон судалгааны нэгдсэн үр дүнг харуулах хавсралт хүснэтүүдээс бүрдсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн бичил уурхайн талаар бодлого боловсруулж шийдвэр гаргах, энэ салбарт хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэгт суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

Судалгааг удирдан зохион байгуулж амжилттай явуулсан ҮСХ-ны ЭЗСГ, МТГ, аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсийн хамт олон, сумдын статистикийн асуудал хариуцсан ажилтан, багийн засаг дарга, тоологч, “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо”-ны гишүүд, судалгааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласан ҮСХ-ны ЭЗСГ, УУХҮЯ, ХНХЯ, АМГТГ, ГБХЗХГ, УБЕГ, ГЕГ зэрэг байгууллагуудын албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсгийн гишүүдэд гүн талархал илэрхийлж байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА



Б.БАТДАВАА

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



1.1 СУДАЛГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг хамралт сайтай явуулах, судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад хяналт, үнэлгээ хийх, холбогдох арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, судалгааны үр дүнг тайлагнах ажлын хэсгийг байгуулан ажилласан. Ажлын хэсэгт ҮСХ, УУХҮЯ, ХНХЯ, АМГТГ, ГБХЗХГ, ГЕГ, УБЕГ, Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо зэрэг 8 байгууллагын 13 төлөөлөл орж ажилласан.

Судалгааг орон нутагт удирдан зохион байгуулах, судалгааны мэдээлэл цуглуулалтын явц болон тулгарч буй асуудлын талаар ажлын хэсгийн гишүүдэд танилцуулах, холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэг бүхий аймаг, сумын ажлын хэсгийг байгуулсан.

Бичил уурхай эрхлэгчдэд судалгааны ач холбогдлыг тайлбарлах, Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн дагуу мэдээллийн нууцыг хадгална гэдгийг ойлгуулж судалгаанд бүрэн хамруулах, мэдээллийг үнэн зөв цуглуулахад анхаарч ажилласан.

1.2 СУРГАЛТ

Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд орон нутагт судалгааг зохион байгуулах ахлагч, судалгааны мэдээлэл цуглуулах судлаач нарт зориулсан сургалтыг 2021 оны 8 дугаар сарын 5-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтаар дараах мэдлэг, мэдээллийг олгосон. Үүнд:

1. Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны үзэл баримтлал, зохион байгуулалт;
2. Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны асуулга, түүнийг нөхөх заавар, анхаарах асуудлууд;
3. Мэдээллийн үнэн зөвийг шалгах аргачлал;
4. Мэдээллийг шивэх программ хангамжийн талаар;

Цар тахалтай холбоотойгоор сургалтыг цахимаар хийсэн учраас мэдээлэл цуглуулах судлаач нарын мэдлэг, ойлголтыг бататгах зорилгоор аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраас давтан сургалтыг зохион байгуулсан.

1.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

Энэ судалгаанд бичил уурхайн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар оролцдог бүртгэгдсэн, бүртгэгдээгүй нөхөрлөл, хоршоо, хувиараа ашигт малтмал олборлогч болон туслах үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийг хамруулсан.

Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны ерөнхий хамрах хүрээ, байршлыг дараах мэдээлэлд үндэслэн тогтоосон. Үүнд:

1. **Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраас авсан судалгаа:** Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраас тухайн орон нутагт бичил уурхай үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөл, хоршоо, иргэдийн бүртгэлийг гаргуулан авсан.
2. **"Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо"-ны мэдээлэл:** "Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо" төрийн бус байгууллагад бүртгэлтэй нөхөрлөл, хоршоодын мэдээллийг гаргуулан авсан.

3. “Ашигт малтмал, газрын тосны газар”-ын мэдээлэл: Ашиглаж байгаа, нөхөн сэргээсэн, дүгнэлт гарсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх боломжтой уурхайн байршлын мэдээллийг гаргуулан авсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг ашигт малтмалын төрөл, олборлолт хийдэг хугацаанаас хамааруулан 2 хувааж хийсэн. Эхний мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 8 болон 9 дүгээр саруудад 19 аймгийн 101 сум, хоёр дахь мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 11 дүгээр сард 5 аймгийн 5 сумыг хамруулан зохион байгуулсан.

Сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн судлаач нар сонгогдсон сумынхаа ашигт малтмалын илрэл бүхий орд, газруудад биечлэн очиж, бичил уурхай эрхлэгчдээс асуулгын дагуу судалгааг авсан бөгөөд судалгаа явагдах үеэр бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийг аль болох бүрэн хамруулах зорилгоор судлаач нар орд газруудад 2-3 удаагийн давтамжтайгаар очиж, мэдээллийг цуглуулсан.

Бичил уурхайн үйл ажиллагааг байнга эрхэлдэг боловч судалгаа явагдах хугацаанд тухайн орд газарт ажиллаагүй иргэдийг орхигдуулахгүй байх чиглэлийг аймаг, нийслэлийн ажлын багт өгснөөр анхан шатны бүртгэлд үндэслэн тулгалтыг хийж судалгаанд хамруулсан.

1.4 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд дараах ойлголт, тодорхойлолтыг ашигласан. Үүнд:

Ойлголт	Тодорхойлолт
АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	
Бичил уурхай эрхлэх	Монгол Улсын “Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23-д зааснаар “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагаа” юм.
Бичил нөхөрлөл/хоршоо уурхайн	Монгол Улсын Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдаж, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох” журамд зааснаар үйл ажиллагаа явуулж байгаа бүлэг хүмүүсийг хэлнэ.
Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид	Нөхөрлөл/хоршооны ахлагч, гишүүд, хувирараа/дангаараа ашигт малтмал олборлогчид, бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчид, гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчдыг нийтэд нь хэлнэ.
Нөхөрлөл/хоршооны ахлагч/ ажил олгогч	Нөхөрлөл/хоршооны зарчмаар хэсэг бүлэг хүнийг нэгдсэн удирдлагаар хангах, цалин хөлс олгох, орлогоо хуваарилах, нөхөрлөлийн гишүүдийн өмнөөс гэрээ байгуулах, хариуцлага хүлээх чадвар бүхий этгээдийг хэлнэ.
Нөхөрлөл/хоршооны гишүүн	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.2.1, 2.2.2-д заасан шаардлага хангасан, ашигт малтмал олборлох зорилгоор хамтран ажиллах гэрээ байгуулсан иргэнийг хэлнэ.
Хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч	Ямар нэгэн нөхөрлөлд харьяалагддаггүй, хувиараа/дангаараа ашигт малтмал олборлож буй иргэнийг хэлнэ.
Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч	Бичил уурхайн үйл ажиллагаанд ашигт малтмал худалдан авах, хүнс, барааны худалдаа эрхлэх, зоогийн газрын үйл ажиллагаа эрхлэх, тээврийн хэрэгслээр үйлчлэх зэрэг ашигт малтмалын олборлолтод шууд гардан оролцдоггүй, туслах үйл ажиллагаа эрхлэгчийг хэлнэ.
Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч	Бичил уурхайн үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцогч гэр бүлийн гишүүнийг хэлнэ.

1.5 СУДАЛГААНЫ АСУУЛГА, ТҮҮНИЙ АГУУЛГА

Энэ удаагийн судалгааны асуулгыг боловсруулахдаа өмнөх судалгааны сургамж болон хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн бөгөөд тэдний өнөөгийн дүр төрхийг харуулж чадахуйц 9 бүлэг, 95 үндсэн үзүүлэлт бүхий асуулгыг нөхөх зааврын хамт боловсруулсан.

Судалгааны асуулгын эхний хувилбарыг боловсруулсны дараа Сэлэнгэ аймгийн Тариат болон Төв аймгийн Хүрээт, Бэлх зэрэг орд газруудад очиж алт олборлодог иргэдээс асуулга авч, туршсан.

Түүнчлэн аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар болон “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо”, Санхүүгийн зохицуулах хороо, Ашигт малтмал, газрын тосны газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам зэрэг холбогдох байгууллагын саналыг авч тусгасан.

Судалгааны үзэл баримтлал, асуулга, нөхөх зааврыг ҮСХ-ны Аргазүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ҮСХ-ны даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/98 тоот тушаалаар батлуулсан.

Судалгааны асуулга нь дараах агуулгаас бүрдэнэ. Үүнд:

Бүлэг 1. Хаягийн хэсэг (8 асуулт): Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа байршлын мэдээлэл;

Бүлэг 2. Ерөнхий мэдээлэл (7 асуулт): Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч иргэний талаарх ерөнхий мэдээлэл;

Бүлэг 3. Ажил эрхлэлт (12 асуулт): Бичил уурхай эрхлэгчдийн ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл;

Бүлэг 4. Мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл авах суваг (4 асуулт): Бичил уурхай эрхлэгчдийн мэдээлэл хүлээн авдаг эх үүсвэр, интернэт, гар утасны хэрэглээний талаарх мэдээлэл;

Бүлэг 5. Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээлэл (8 асуулт): Бичил уурхай эрхлэгчдийн бэртэл, гэмтэл, өвчлөлт, эмнэлгийн тусламж авах боломжийн талаарх мэдээлэл;

Бүлэг 6. Техник, тоног, төхөөрөмж (5 асуулт): Бичил уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног, төхөөрөмж болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн талаарх мэдээлэл;

Бүлэг 7. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл (24 асуулт): Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны орлого, зардлын талаарх мэдээлэл;

Бүлэг 8. Тусламж, дэмжлэг, тулгарч буй хүндрэл, бэрхшээл (17 асуулт): Бичил уурхай эрхлэгчдийн төрийн болон төрийн бус байгууллагаас авч байсан дэмжлэг, тусламж, үйл ажиллагаа явуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаарх мэдээлэл;

Бүлэг 9. Хүүхдийн эрх (10 асуулт): Бичил уурхайн үйл ажиллагаан дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, оролцож буй хэлбэр, бэртэл гэмтлийн талаарх мэдээлэл. (Асуулгыг Хавсралт 1-ээс харна уу).

1.6 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээллийг цаасан маягтаар цуглуулсан ба мэдээллийг нэгтгэх, шалгах, үр дүнг боловсруулах, статистик дүн шинжилгээг хийхэд CsPro болон STATA программ хангамж ашигласан.

Цуглуулсан мэдээллийг шалгахдаа маягтын үзүүлэлт хоорондын уялдаа холбоо, балансын болон логик шалгалтыг хийж, зарим шаардлагатай засварлалтуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн аж үйлдвэрийн салбарын сарын мэдээ, дотоодын зах зээлийн ашигт малтмалын нэгжийн дундаж үнэ зэрэг мэдээлэлтэй уялдуулж шалгасан.

БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ




II.1 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД

Бичил уурхай эрхлэгчдийн 2021 оны судалгаагаар нийт 9727 иргэн бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаагийн 3423 иргэн нь судалгаанд хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 596 нь нөхөрлөл, хоршооны ахлагч (гишүүн), 2658 нь хувиараа (дангаараа) бичил уурхай эрхлэгч, 169 нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч иргэн байна. Судалгаагаар нөхөрлөл, хоршооны дарга, гишүүдээс тэдгээрийн нийт гишүүдийн тоог тусад асуусан ба 596 нөхөрлөл хоршооны нийт гишүүдийн тоо 6521 байна. Мөн хувиараа (дангаараа) бичил уурхай эрхлэгч иргэдийн ам бүлийн гишүүдээс 379 иргэн бичил уурхай эрхэлж байна.

ЗУРАГ 1. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, ажил эрхлэлтийн байдлаар



Нийт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 9558 (98.3%) нь бичил уурхай эрхлэгч, 169 (1.7%) нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч байна.

ХҮСНЭГТ 1. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, бүсээр

Бүс	БҮГД	Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын төрөл		
		Нөхөрлөл хоршооны дарга/гишүүн	Хувиараа (дангаараа) бичил уурхай эрхлэгч, гэр бүлийн гишүүд	Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч
БҮГД	9 727	6 521	3 037	169
Баруун	3 646	1 981	1 650	15
Хангайн	2 045	1 691	349	5
Төвийн	3 173	2 137	997	39
Зүүн	863	712	41	110

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 3.6 (37.5%) мянга нь Баруун бүсэд, 3.2 (32.6%) мянга нь Төвийн бүсэд, 2.0 (21.0%) мянга нь Хангайн бүсэд, 0.9 (8.9%) мянга нь Зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна.

Нийт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 2.0 (20.2%) мянга нь эмэгтэйчүүд байна. Бүсээр авч үзвэл, баруун бүсэд 627 (31.9%), хангайн бүсэд 624 (31.8%), төвийн бүсэд 560 (28.5%), зүүн бүсэд 153 (7.8%) бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаа эмэгтэйчүүд байна.


Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо 0.4 хувиар, Төвийн бүсийнх 5.4 хувиар буурсан бол Хангайн бүсийнх 56.9 хувиар, Зүүн бүсийнх 4.4 дахин тус тус өсжээ.

ХҮСНЭГТ 2. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, бүсээр, хүйсээр

	2012	Эмэгтэй	2016	Эмэгтэй	2021	Эмэгтэй
БҮГД	13 375	3 915	9 596	2 301	9 558	1 917
Баруун	3 380	1 010	3 597	857	3 631	618
Хангайн	3 967	1 355	1 300	380	2 040	621
Төвийн	4 403	1 295	3 312	879	3 134	549
Зүүн	365	87	171	39	753	129
Улаанбаатар	1 260	168	1 216	146	-	-

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдыг байршлаар авч үзэхэд Улаанбаатар хот, Сүхбаатар, Говьсүмбэр аймгаас бусад 19 аймагт үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн 1.9 (19.9%) мянга нь Сэлэнгэ аймагт, 1.9 (19.6%) мянга нь Увс аймагт, 1.0 (10.1%) мянга нь Баянхонгор аймагт, 0.8 (8.7%) мянга нь Говь-Алтай аймагт, 0.8 (8.5%) мянга нь Хэнтий аймагт, 0.6 (6.5%) мянга нь Ховд аймагт, 0.5 (5.4%) мянга нь Булган аймагт байгаа нь нийт иргэдийн 78.6 хувийг эзэлж байгаа бол үлдсэн 21.4 хувь нь бусад аймагт байна.

ЗУРАГ 1. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, аймаг, нийслэлээр, бичил уурхай эрхлэгчдийн тооны бүлгээр



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдыг нутаг дэвсгэрийн байршлаар нь авч үзвэл, 19 аймгийн 103 сумын ашигт малтмалын илрэл бүхий 180 орчим орд газрын цэг, бичил уурхайн аманд үйл ажиллагаа явуулж байгаа иргэд байна.

II.2 БИЧИЛ УУРХАЙН ОРД ГАЗРЫН ТОО


Ашигт малтмалын илрэл бүхий нийт 180 гаруй орд газрын цэг, бичил уурхайн аманд үйл ажиллагаа явагдаж байгаагийн 102 (55.7%) нь 4 аймагт байршиж, тэдгээрийн 46 нь Баянхонгор аймагт, 27 нь Сэлэнгэ аймагт, 18 нь Өмнөговь аймагт, 11 нь Говь-Алтай аймагт байна.

ЗУРАГ 2. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, ОРД ГАЗРЫН ТОО, аймгаар




Ашигт малтмалын орд олонтой дээрх 4 аймагт, 4.1 мянган бичил уурхай эрхлэгчид байгаагийн 1.9 (47.1%) мянга нь Сэлэнгэ аймагт, 1.0 (23.9%) мянга нь Баянхонгор аймагт, 0.8 (20.7%) мянга нь Говь-Алтай аймагт, 0.3 (8.4%) мянга нь Өмнөговь аймагт байна.

ЗУРАГ 3. НЭГЖ ОРД ГАЗАРТ НОГДОХ БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, аймгаар



Нэгж орд газарт ногдох бичил уурхай эрхлэгчдийн тоо улсын дунджаар 53, үүнээс Увс аймагт 238, Булган аймагт 131, Архангай аймагт 106, Ховд аймагт 105, Хэнтий аймагт 103, Төв аймагт 86, Говь-Алтай аймагт 77, Сэлэнгэ аймагт 72 ногдож, бусад аймаг улсын дунджаас нягтаршил багатай байна.

ЗУРАГ 4. БИЧИЛ УУРХАЙД АШИГЛАГДАЖ БУЙ ОРД ГАЗРЫН ТОО, аймаг, нийслэлээр, ашигт малтмалын төрлөөр



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоогоор уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох алтны илрэл бүхий орд газар ихтэй Увс, Сэлэнгэ, Баянхонгор, Говь-

Алтай, Хэнтий, Ховд, Булган зэрэг аймгууд тэргүүлж байна. Харин нүүрс, жонш, шохойн чулуу зэрэг ашигт малтмалын илрэл бүхий орд газартай аймгууд доогуур байранд орж байна. Үүнээс харахад бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын төвлөрөл нь ашигт малтмалын төрлөөс шууд хамааралтай байна.

II.3 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖЭЭР

Судалгаанд нийт 3423 бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхэлж буй иргэд хамрагдсан бөгөөд дараагийн хэсгүүдэд эдгээр иргэдийн дүнгээр үр дүн бичигдсэн болно.

ХҮСНЭГТ 3. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД, аймаг, нийслэл, засаг захиргааны харьяаллаар

Засаг, захиргааны харьяалал (Үндсэн захиргаа)

	УБ	ДО	СҮ	ХЭ	ТӨ	ГС	СЭ	ДГ	ДА	ӨМ	ДУ	ОР	ӨВ	БУ	БХ	АР	ХӨ	ЗА	ГА	БӨ	ХО	УВ	
УБ																							
ДО		30																					
СҮ																							
ХЭ	25	3	1	167	1			16	1									1					
ТӨ	13				412		2		11			1		2			1						2
ГС																							
СЭ	12				3		317									2							
ДГ								37					1										
ДА					20		3		12														
ӨМ										298													
ДУ	5				1	1		3		4	106												
ОР					9		2			1			6	1				1					
ӨВ													80										
БУ														58									
БХ															132	1							
АР															1	80							
ХӨ								1		2							50						
ЗА																		145	2				
ГА	10											3		1					458	3			2
БӨ																				66			
ХО																						497	
УВ																							297

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдыг засаг захиргааны харьяаллаар авч үзвэл Өмнөговь, Дорнод, Ховд, Увс аймгуудад бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй иргэд тухайн нутгийн харьяат иргэд байна. Харин Хэнтий аймагт бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн 77.7 хувь нь тухайн нутгийн харьяат, 11.6 хувь нь Улаанбаатар хотын харьяат, үлдсэн 10.7 хувь нь бусад аймгийн харьяат иргэд байгаа бол бусад аймгийн бичил үйл ажиллагаа эрхлэгчдийн 88.3-99.2 хувь нь тухайн нутгийнхаа харьяат байна.

II.4 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Судалгаанд хамрагдсан 3.4 мянган бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхлэгчдийг насны бүлгээр авч үзвэл, 0.8 хувь нь 18-19 насных, 14.0 хувь нь 20-29 насных, 30.9 хувь нь 30-39 насных, 32.6 хувь нь 40-49 насных, үлдсэн 21.7 хувь нь 50 ба түүнээс дээш насны иргэд байна. Эндээс харахад нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн дийлэнх нь хөдөлмөрийн зах зээлд оролцож буй ажиллах хүч болох 20-54 насных байгаа нь орон нутагт байнгын ажлын байр хомс байгааг харуулж байна. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын хүйс, насны бүлгээрх дэлгэрэнгүй үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.

ХҮСНЭГТ 4. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, насны бүлгээр, хүйсээр

Насны бүлэг	Бүгд		
		Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	3 423	2 730	693
18-19	28	25	3
20-24	182	156	26
25-29	296	249	47
30-34	493	409	84
35-39	566	467	99
40-44	610	484	126
45-49	505	397	108
50-54	388	279	109
55-59	234	172	62
60-64	96	74	22
65+	25	18	7

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 79.8 хувь нь эрэгтэй, 20.2 хувь эмэгтэй, хүйсийн харьцаа 100 эрэгтэй тутамд 39 эмэгтэй ногдож байна. Харин уг үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл, 18-19 насныхны хувьд хамгийн их буюу 100 эрэгтэй тутамд 83 эмэгтэй ногдож байгаа бол 50-59 насныхны хувьд 100 эрэгтэй тутамд 26 эмэгтэй ногдож байна.


Харин эмэгтэй иргэдийн 0.4 хувь нь 18-19 насных, 10.5 хувь нь 20-29 насных, 26.4 хувь нь 30-39 насных, 33.8 хувь нь 40-49 насных, үлдсэн 28.9 хувь нь 50, түүнээс дээш насных байна.

ХҮСНЭГТ 5. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бүс, насны бүлгээр

Бүс	БҮГД											
		18-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65+
БҮГД	3 423	28	182	296	493	566	610	505	388	234	96	25
Баруун	1 484	12	63	130	194	237	277	231	197	94	42	7
Хангайн	425	2	17	30	65	81	74	56	45	36	17	2
Төвийн	1 269	14	88	121	200	195	212	177	121	93	33	15
Зүүн	245		14	15	34	53	47	41	25	11	4	1

Улсын хэмжээнд 65, түүнээс дээш насны 25 иргэн бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж, тэдний 15 нь Төвийн бүсэд, үлдсэн 10 нь Баруун, Хангайн, Зүүн бүсэд байна.

ЗУРАГ 5. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙГ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоог ижил интервалтай насны бүлгээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь эрэгтэйчүүд бичил уурхайн үйл ажиллагаанд илүү давамгайл байдлаар оролцдогийг харуулж байна.

II.5 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд нь боловсролын түвшнээс ихээхэн хамаардаг. Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан 3.4 мянган бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн боловсролын түвшинг авч үзлээ.

ХҮСНЭГТ 6. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, бүсээр

Бүс	БҮГД	Боловсролгүй	Боловсролтой	Боловсролын түвшин					
				Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
БҮГД	3 423	121	3 302	270	687	1 580	326	125	314
Баруун	1 484	63	1 421	128	261	771	101	29	131
Хангайн	425	31	394	47	106	160	24	11	46
Төвийн	1 269	24	1 245	84	263	523	192	72	111
Зүүн	245	3	242	11	57	126	9	13	26

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 0.1(3.5%) мянга нь боловсролгүй, 3.3 (96.5%) мянга нь боловсрол эзэмшсэн иргэд байна. Бичл уурхай эрхлэгчдийн 270 (7.9%) нь бага боловсролтой, 687 (20.1%) нь суурь боловсролтой, 1581(46.2%) мянга нь бүрэн дунд боловсролтой, 326 (9.5%) нь техникийн болон мэргэжлийн боловсролтой, 125 (3.7%) нь тусгай мэргэжлийн дунд, 314 (9.2%) нь дээд боловсролтой байна.

ХҮСНЭГТ 7. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР

Боловсролын түвшин	БҮГД			Эрэгтэй			Эмэгтэй		
	2012	2016	2021	2012	2016	2021	2012	2016	2021
	БҮГД	100.0	100.0	100	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	4.1	2.2	3.5	4.2	2.4	3.5	4.0	1.6	3.6
Боловсролтой	95.9	97.8	96.5	95.8	97.6	96.5	96.0	98.4	96.4
Бага	14.0	10.6	7.9	14.9	11.0	8.4	11.7	9.4	6.1
Суурь	27.9	36.7	20.1	28.6	37.6	20.8	26.4	33.9	17
Бүрэн дунд	40.4	35.9	46.2	39.3	35.4	46.6	42.8	37.4	44.6
Техникийн болон мэргэжлийн	6.8	5.1	9.5	7.3	5.2	9.4	5.3	4.7	10.0
Тусгай мэргэжлийн дунд	2.6	3.0	3.7	2.0	2.5	3.1	4.3	4.7	5.8
Дээд	4.2	6.5	9.2	3.7	5.9	8.2	5.5	8.3	13.0

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн боловсролын түвшинг хүйсээр харвал бараг бүх түвшинд ойролцоо байгаа ба дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 4.8 нэгж хувиар илүү байна.

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад боловсролтой бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын эзлэх хувь 1.3 нэгж хувиар буурч, үүнээс бага боловсролтой иргэдийнх 2.7, суурь боловсролтой иргэдийнх 16.6 нэгж хувиар тус тус буурсан байна.

II.6 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ МЭРГЭЖИЛ

Судалгаанд хамрагдсан 3.4 мянган бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн 2032 (59.3%) нь мэргэжилгүй, 455 (13.3%) хувь нь машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч, 311 (9.1%) нь мэргэжилтэн, 290 (8.5%) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, үйлчилгээний, 194 (5.7%) хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, үлдэх 141 (4.1%) хувь нь менежер, техникч болон туслах/дэд мэргэжилтэн, контор, үйлчилгээний ажилтан болон энгийн ажил, мэргэжилтэй иргэд байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ажил, мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүд ажил, мэргэжлийн ангилал бүрд ялгаатай байгаа нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 8. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ажил мэргэжлээр, хүйсээр

Ажил мэргэжлийн бүлэг	БҮГД	Хүйсээр	
		Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	3 423	2 730	693
Менежер	20	16	4
Мэргэжилтэн	311	210	101
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	32	18	14
Контор, үйлчилгээний ажилтан	10	6	4
Худалдаа, үйлчилгээний ажилтан	77	14	63
ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	194	141	53
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, үйлчилгээ	290	214	76
Машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч	454	435	19
Энгийн ажил, мэргэжил	3	3	-
Мэргэжилгүй	2 032	1 673	359

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн эзэмшсэн мэргэжлийг бүсээр авч үзвэл, мэргэжилгүй иргэдийн 53.0 хувь нь Баруун бүсэд, 30.7 хувь нь Төвийн бүсэд, 9.3 хувь нь Хангайн бүсэд, 7.0 хувь нь Зүүн бүсэд, харин машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагчийн мэргэжилтэй бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 57.8 хувь нь Төвийн бүсэд, 24.6 хувь нь Баруун бүсэд, 10.1 хувь нь Хангайн бүсэд, 7.5 хувь нь Зүүн бүсэд байна.

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуй, ой загас агнуурын мэргэшсэн ажилтан, машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч, техникч болон туслах, худалдаа үйлчилгээний ажилтан, контор, үйлчилгээний ажилтан иргэдийн эзлэх хувь 0.1-3.2 нэгж хувиар буурч, менежер, мэргэжилтэн, үйлдвэрлэл, барилга, гар урлал, үйлчилгээний ажил мэргэжилтэй болон мэргэжилгүй иргэдийнх 0.2-3.3 нэгж хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 9. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бүс, ажил мэргэжлээр

Бүс	БҮГД	Ажил мэргэжлээр										
		Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Менежер	Мэргэжилтэн	Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	Контор, үйлчилгээний ажилтан	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	Машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч	Энгийн ажил, мэргэжил	Мэргэжилгүй
БҮГД	3 423	-	20	311	32	10	77	194	290	454	3	2 032
Баруун	1 484	-	6	137	8	4	29	35	77	111	-	1 077
Хангайн	425	-	5	42	7	2	8	107	20	46	-	188
Төвийн	1 269	-	8	106	11	4	35	51	165	263	2	624
Зүүн	245	-	1	26	6		5	1	28	34	1	143

II.7 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АМ БҮЛИЙН ТОО

Судалгаанд хамрагдсан 3.4 мянган бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 73.2 хувь нь 2-5 ам бүлтэй, 19.1 хувь нь 6-9 ам бүлтэй, 7.4 хувь нь 1 ам бүлтэй, 0.3 хувь нь 10 ба түүнээс дээш ам бүлтэй байна.

ЗУРАГ 6. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АМ БҮЛИЙН ТОО, судалгаа явагдсан оноор, дүнд эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ам бүлийн дундаж тоо 4.1 байгаа ба бүсээр авч үзвэл Баруун бүсэд хамгийн өндөр буюу 4.4, Зүүн бүсэд хамгийн бага буюу 3.6 байна.

**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ**




Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ажил эрхлэлтийн байдал, ажилласан жил, уг үйл ажиллагааг эрхлэх болсон шалтгаан, үйл ажиллагаа явуулж буй газрын орчин нөхцөл зэрэг үзүүлэлтийг хамруулсан.

III.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Бичил уурхай эрхлэгчдийн 2021 оны судалгаанд нийтдээ 3.4 мянган иргэн хамрагдсан нь 2016 оны судалгаанд хамрагдсан иргэдээс 6.2 мянга буюу 64.3 хувиар бага байна.

Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн баталсан ба уг журамд бичил уурхай эрхлэгч этгээд нь Иргэний хуулийн 35.1-д заасан нөхөрлөл, 36.4-т заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд, мөн хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэртэй байна гэж заасан. Журам шинэчлэгдэн батлагдсанаар өмнөх судалгаанаас хойш бичил уурхай эрхлэгчид нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтанд түлхүү орж, үйл ажиллагаагаа явуулж байна. Тиймээс энэ удаагийн судалгаанд нөхөрлөл хоршооны аль нэгэн гишүүнээс төлөөлүүлэн мэдээллийг авлаа.

ЗУРАГ 7. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ажил эрхлэлтийн байдлаар



Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 0.2 хувь нь хоршооны дарга, гишүүн, 4.9 хувь нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч, 17.2 хувь нь нөхөрлөлийн ахлагч, гишүүн, 77.7 хувь нь хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч иргэд байна.

Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн 874 (25.5%) нь бичил уурхайгаас өөр төрлийн ажил давхар эрхэлж байна.

ХҮСНЭГТ 10. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, бүсээр

Бүс	БҮГД	Нөхөрлөлийн ахлагч/дарга	Нөхөрлөлийн гишүүн	Хоршооны ахлагч болон гишүүн	Хувиараа (дангаараа) ашигт малтмал олборлогч	Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч
БҮГД	3 423	355	233	8	2 658	169
Баруун	1 484	57	57	3	1 352	15
Хангайн	425	166	23	1	230	5
Төвийн	1 269	124	89	3	1 014	39
Зүүн	245	8	64	1	62	110


Нөхөрлөл 596 байгаагийн 36.2 хувь нь Төвийн бүсэд, 31.9 хувь нь Хангайн бүсэд, 19.6 хувь нь Баруун бүсэд, 12.2 хувь нь Зүүн бүсэд ногдож байна. Эндээс харахад Төвийн болон Хангайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй бичил уурхай эрхлэгчид нөхөрлөлийн хэлбэрт түлхүү шилжсэн нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан 2658 хувиараа (дангаараа) бичил уурхайн эрхлэгчдийг бүсээр авч үзвэл: 50.9 хувь нь Баруун бүсэд, 38.1 хувь нь Төвийн бүсэд, 8.7 хувь нь Хангайн бүсэд, 2.3 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчид 169 байгаагийн 65.1 хувь нь Зүүн бүсэд, 23.1 хувь нь Төвийн бүсэд, 8.9 хувь нь Баруун бүсэд, 3.0 хувь нь Хангайн бүсэд ногдож байна.

Нөхөрлөл, хоршоо: Судалгаанд хамрагдсан нөхөрлөл, хоршооны нийт гишүүдийн тоо 6521 байгаагийн 75.7 хувь нь эрэгтэй, 24.3 хувь нь эмэгтэй байна.

ЗУРАГ 8. НӨХӨРЛӨЛ, ХОРШООНЫ ГИШҮҮДИЙН ТОО, аймгаар



Нөхөрлөл, хоршооны гишүүдийн тоог аймгаар харвал Увс, Сэлэнгэ аймгуудад хамгийн их, Баян-Өлгий, Ховд, Архангай, Төв, Өмнөговь, Дорнод аймгуудад хамгийн бага байна.

ХҮСНЭГТ 11. НӨХӨРЛӨЛ, ХОРШОО, ГИШҮҮДИЙН ТОО, хүйсээр

	2012		2016		2021	
	Нөхрөл, хоршоо	Гишүүд	Нөхрөл, хоршоо	Гишүүд	Нөхрөл, хоршоо	Гишүүд
БҮГД	295	1 930	326	2 024	596	6521
Эрэгтэй		1471		1507		4934
Эмэгтэй		459		517		1587


Нөхөрлөл, хоршооны тоо өмнөх судалгааны дүнгээс 270 (82.8%), гишүүдийн тоо 4.5 мянгаар буюу 3.2 дахин нэмэгдсэн байна. Эндээс үзэхэд өмнөх тооллогоос хойш бичил уурхайн эрхлэгчид нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтанд түлхүү орж байгааг харуулж байна. Нөхөрлөл, хоршооны гишүүдийн 4.9 (75.7%) мянга нь эрэгтэй, 1.6 (24.3%) мянга нь эмэгтэй байгаа нь өмнөх судалгааны дүнгээс эрэгтэйчүүдийн эзлэх хувь 1.2 нэгж хувиар нэмэгдэж, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1.2 нэгж хувиар буурчээ.

III.2 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХУГАЦАА, ШАЛТГААН

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 20.2 хувь нь нэг хүртэлх жил, 27.1 хувь нь 2-3 жил, 17.0 хувь нь 4-5 жил, 7.0 хувь нь 6-7 жил, 6.1 хувь нь 8-9 жил, 11.4 хувь нь 10-11 жил, 11.2 хувь нь 12, түүнээс дээш жил ажилласан байна.


Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн дийлэнх нь буюу 47.3 хувь нь 3 хүртэлх жил ажилласан байгаа нь сүүлийн жилүүдэд иргэд бичил уурхайн салбарт шинээр татагдан орж байгааг харуулж байна.

ЗУРАГ 9. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бичил уурхайд ажилласан жилээр, дүнд эзлэх хувиар



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ажилласан жилийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2-3 жил ажилласан иргэдийн эзлэх хувь 1.6 нэгж хувиар, 4-5 жил ажилласан иргэдийнх 2.4 нэгж хувиар, 6-7 жил ажилласан иргэдийнх 1.8 нэгж хувиар буурч, 1 хүртэлх жил ажилласан иргэдийн эзлэх хувь 0.7 нэгж хувиар, 8-9 жил ажилласан иргэдийнх 0.9 нэгж хувиар, 10-11 жил ажилласан иргэдийнх 2.2 нэгж хувиар, 12 ба түүнээс дээш жил ажилласан иргэдийнх 2.0 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 10. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бичил уурхай эрхэлж буй шалтгаанаар, дүнд эзлэх хувиар



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 42.1 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 40.1 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 13.2 хувь нь бусад шалтгаанаар, 4.6 хувь нь малгүй болсон учраас бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

Баруун бүсийн бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 44.6 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 39.4 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 8.5 хувь нь бусад ажлын байрны шаардлага өндөр, 4.8 хувь нь малгүй болсноос, 2.6 хувь нь бичил уурхайтай өрсөлдөх өөр орлого олох ажил олдоогүй болон бусад зорилгоор бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн гэж хариулжээ.

ХҮСНЭГТ 12. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, бичил уурхай эрхэлж буй шалтгаанаар, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар

Бүс	БҮГД	Бичил уурхайтай өрсөлдөх өөр орлого олох ажил олдоогүй					
		Байнгын ажлын байр олдоогүй	Бичил уурхайтай өрсөлдөх өөр орлого олох ажил олдоогүй	Бусад ажлын байрны шаардлага өндөр	Малгүй болсон	Нэмэлт орлого олох зорилгоор	Бусад
БҮГД	100.0	42.1	4.2	8.4	4.6	40.1	0.6
Баруун	100.0	39.4	2.3	8.5	4.8	44.6	0.3
Хангайн	100.0	35.2	8.2	3.6	6.2	44.9	2.0
Төвийн	100.0	46.1	5.1	9.0	3.8	35.6	0.3
Зүүн	100.0	49.6	3.9	12.8	5.0	27.6	1.2

Харин Хангайн бүсийн хувьд 44.9 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 35.2 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 8.2 хувь нь бичил уурхайтай өрсөлдөх өөр орлого олох ажил олдоогүйгээс, 6.2 хувь нь малгүй болсноос, 3.6 хувь нь бусад ажлын байрны шаардлага өндөр болон бусад зорилгоор бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

Төвийн бүсийн хувьд 46.1 хувь нь байнгын ажлын байр олоогүйгээс, 35.6 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 9.0 хувь нь бусад ажлын байрны шаардлага өндөр, 5.1 хувь нь бичил уурхайтай өрсөлдөх өөр орлого олох ажил олдоогүйгээс, 3.8 хувь нь малгүй болсон болон бусад шалтгаанаар бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлж байна.


Зүүн бүсийн хувьд 49.6 хувь нь байнгын ажлын байр олоогүйгээс, 27.6 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 12.8 хувь нь бусад ажлын байрны шаардлага өндөр, 5.0 хувь нь малгүй болсноос, 5.1 хувь нь бичил уурхайтай өрсөлдөх өөр орлого олох ажил олдоогүй болон бусад шалтгаанаар бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлж байна.

III.3 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, УНДНЫ УС

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй газрын амьдрах орчин нөхцлийн талаар энэ хэсэгт авч үзсэн.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн сууцны төрөл: Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 2.0 (59.5%) мянга нь үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа өөрийн байнгын амьдардаг сууцнаас тусдаа бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй орд газарт байрладаг гэж хариулжээ. Эдгээр иргэдийг байрладаг сууцны төрлийг авч үзвэл:

ЗУРАГ 11. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, эзэмшлийн хэлбэрээр



Сууцанд амьдардаг гэж хариулсан иргэдийн 36.0 хувь нь гэрт, 33.0 хувь нь майханд, 15.7 хувь нь бусад хэлбэрийн сууцанд, 11.9 хувь нь түр оромжид, 2.8 хувь нь байшинд, 0.6 хувь нь нүхэн сууцанд амьдардаг байна. Үүнээс харахад сууцанд амьдардаг иргэдийн 61.2 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байгаа ба өмнөх судалгааны дүнгээс 7.6 нэгж хувиар өсжээ.

ХҮСНЭГТ 13. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, бүсээр, хувиар

Бүс	БҮГД	Гэр	Байшин	Майхан	Түр оромж /отог/	Нүхэн сууц	Бусад
БҮГД	100.0	36.0	2.8	33.0	11.9	0.6	15.7
Баруун	100.0	24.1	0.1	44.7	16.1	0.1	14.8
Хангайн	100.0	81.4	0.5	11.8	-	-	6.4
Төвийн	100.0	35.1	3.0	26.1	10.2	1.6	23.9
Зүүн	100.0	72.4	24.3	0.5	2.7	-	-


Баруун бүсийн 75.8 хувь, Төвийн бүсийн 61.9 хувь, Хангайн бүсийн 18.2 хувь, Зүүн бүсийн 3.2 хувь нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх хугацаандаа өөрийн байнга амьдардаг сууцнаас тусдаа зориулалтын бус сууцанд амьдарч байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэр: Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа газрынх нь цахилгааны эх үүсвэрийг энэ хэсэгт авч үзсэн. Цахилгааны эх үүсвэр нь бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай нэг чухал үзүүлэлт юм. Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй газрынх нь цахилгааны эх үүсвэрийн мэдээллийг төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр, цахилгааны эх үүсвэргүй гэж ангилан судаллаа.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн талаас илүү нь буюу 53.6 хувь нь цахилгааны ямар нэгэн эх үүсвэргүй газар үйл ажиллагаа явуулж байна.

Цахилгааны эх үүсвэртэй нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийн 49.9 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүр ашиглан цахилгаан хэрэглэдэг бол 23.1 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан цахилгаанд холбогддог байна. Харин 19.2 хувь нь төвлөрсөн системээс цахилгаан хэрэглэж, 7.8 хувь нь дизель станцтай холбогдсон байна.

ЗУРАГ 12. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, төрлөөр, дүнд эзлэх хувиар



60.6 хувь, өнгөт чулуу олборлогчдын 90.9 хувь, улаан чулуу олборлогчид 100.0 хувь цахилгааны эх үүсвэргүй газар үйл ажиллагаа явуулж байна гэж хариулсан байна.

ХҮСНЭГТ 14. БИЧИЛ УУРХАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, олборлодог ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар

Бүс	БҮГД	Цахилгааны эх үүсвэргүй	Цахилгааны эх үүсвэртэй	Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр
БҮГД	100.0	53.6	46.4	9.5	3.6	10.5	22.8
Алт	100.0	57.5	42.5	4.4	4.0	9.9	24.2
Нүүрс	100.0	50.0	50.0	25.0	-	8.3	16.7
Жонш	100.0	16.5	83.5	40.8	3.2	6.7	32.7
Гянтболд	100.0	-	100.0	-	-	90.9	9.1
Шохойн чулуу	100.0	41.7	58.3	58.3	-	-	-
Элс, хайрга	100.0	19.7	80.3	77.3	-	-	3.0
Давс	100.0	60.6	39.4	-	-	39.4	-
Улаан чулуу	100.0	100.0	-	-	-	-	-
Өнгөт чулуу	100.0	90.9	9.1	-	4.5	4.5	-
Бусад	100.0	53.4	46.6	46.6	-	-	-

Баруун бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 70.0 хувь нь, Хангайн бүсийн 32.9 хувь нь, Төвийн бүсийн 49.5 хувь нь, Зүүн бүсийн 11.4 хувь нь ямар нэгэн цахилгааны эх үүсвэргүй газар үйл ажиллагаа явуулж байна.

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн ундны усны эх үүсвэр: Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа газрын ундны усны эх үүсвэрийг энэ хэсэгт авч үзсэн.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 1 806 (52.8%) нь зөөврийн усаар ундны усаа хангаж байна.

Харин 1183 (34.6%) нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг шандны усаар ундны усны хэрэгцээгээ хангадаг бол 251 (7.3) хувь нь хамгаалагдсан худгийн усаар ундны эх үүсвэрээ хангадаг гэж хариулжээ. Үлдсэн 5.3 хувь нь хамгаалагдсан булаг, шанд, төвлөрсөн систем, цэвэршүүлэн савласан ус зэрэг эх үүсвэрээс ундны усны хэрэгцээгээ хангадаг байна.

ХҮСНЭГТ 15. БИЧИЛ УУРХАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, бүсээр, дүнд эзлэх хувиар

Бүс	БҮГД								
		Төвлөрсөн систем	Төвлөрсөн системд холбогдсон ус	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг, шанд	Цэвэршүүлэн савласан ус	Төвлөрсөн системд холбогдоогүй ус	Зөөврийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд
БҮГД	100.0	0.6	0.1	7.3	1.4	3.1	0.2	52.8	34.6
Баруун	100.0	0.1	0.1	3.5	2.0	2.3	0.1	44.7	47.3
Хангайн	100.0	-	-	17.9	1.4	0.5	-	29.9	50.4
Төвийн	100.0	1.3	0.2	8.0	0.9	5.4	0.1	64.4	19.7
Зүүн	100.0	0.4	0.4	8.6	0.4	-	2.0	81.2	6.9

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ундны усны эх үүсвэрийг бүсээр авч үзвэл Зүүн бүсийн 81.2 хувь, Төвийн бүсийн 64.4 хувь, Баруун бүсийн 44.6 хувь, Хангайн бүсийн 29.9 хувь нь зөөврийн усаар ундны хэрэгцээгээ хангаж байна. Хангайн бүсийн 50.4 хувь, Баруун бүсийн 47.3 хувь, Төвийн бүсийн 19.7 хувь, Зүүн бүсийн 6.9 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандын усаар ундны хэрэгцээгээ хангаж байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ундны усны эх үүсвэрийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл, алт олборлогчдын 51.3 хувь нь зөөврийн уснаас, 37.4 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандаас, үлдсэн 11.3 хувь нь бусад эх үүсвэрээс (төвлөрсөн систем, хамгаалагдсан худаг, хамгаалагдсан булаг, шанд, цэвэршүүлэн савласан ус, төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр) ундны усны хэрэгцээгээ хангаж байна.

ХҮСНЭГТ 16. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, олборлодог ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар

Бүс	БҮГД								
		Төвлөрсөн систем	Төвлөрсөн системд холбогдсон ус	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг, шанд	Цэвэршүүлэн савласан ус	Төвлөрсөн системд холбогдоогүй ус	Зөөврийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд
БҮГД	100.0	0.5	0.1	7.9	1.3	3.1	0.2	52.6	34.2
Алт	100.0	0.6	0.1	5.3	1.5	3.6	0.1	51.3	37.4
Нүүрс	100.0	-	-	16.7	-	8.3	-	58.3	16.7
Жонш	100.0	0.4	1.1	15.5	1.4	-	1.1	76.1	4.6
Гянтболд	100.0	-	-	-	-	-	-	-	100.0
Шохойн чулуу	100.0	-	-	41.7	-	-	-	41.7	16.7

Бүс	БҮГД								
		Төвлөрсөн систем	Төвлөрсөн системд холбогдсон ус	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг, шанд	Цэвэршүүлэн савласан ус	Төвлөрсөн системд холбогдоогүй ус	Зөөврийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд
Элс, хайрга	100.0	-	-	69.7	-	4.5	-	15.2	10.6
Давс	100.0	-	-	-	-	-	-	57.5	42.5
Улаан чулуу	100.0	-	-	-	-	-	-	68.8	31.3
Өнгөт чулуу	100.0	-	-	-	-	-	-	86.4	13.6
Бусад	100.0	-	-	44.8	-	-	-	24.1	31.0

Харин нүүрс олборлогчдын 58.3 хувь, жонш олборлогчдын 76.1 хувь, шохойн чулуу олборлогчдын 41.7 хувь, давс олборлогчдын 57.5 хувь, улаан чулуу олборлогчдын 68.8 хувь, өнгөт чулуу олборлогчдын 86.4 хувь нь зөөврийн усаар удны хэрэгцээгээ хангадаг бол элс хайрга олборлогчдын 69.7 хувь, бусад төрлийн ашигт малтмал олборлогчдын 44.8 хувь, шохойн чулуу олборлогчдын 41.7 хувь нь хамгаалагдсан худагас ундны усны хэрэгцээгээ хангадаг байна.


**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ**

IV

IV.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн 47.6 хувь нь энгийн, 52.4 хувь нь ухаалаг утас ашиглаж байна.

ЗУРАГ 13. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, утасны төрлөөр, дүнд эзлэх хувиар




Үйл ажиллагаа явуулж буй газраа гар утас хэрэглэдэг бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 1667 (79.8%) эрэгтэй, 423 (20.2%) нь эмэгтэй байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад ухаалаг утас хэрэглэгдэг бичил уурхайчдын тоо 26.9 нэгж хувиар өсжээ.

Гар утас хэрэглэдэг эрэгтэй бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 18.2 хувийг 40-44 насныхан, 16.8 хувийг 35-39 насныхан, 14.7 хувийг 45-49 насныхан, 13.7 хувийг 30-34 насныхан эзэлж байгаа бол эмэгтэйчүүдийн 18.7 хувийг 40-44 насныхан, 15.8 хувийг 45-49 насныхан, 15.1 хувийг 50-54 насныхан эзэлж байна.

IV.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 21.0 хувь нь бичил уурхайн, 16.1 хувь нь өдөр тутмын мэдээлэл, 15.0 хувь нь хууль эрх зүй, 12.7 хувь нь нөхөн сэргэлт, байгаль орчны асуудал, 10.7 хувь нь бусад (улс төр, боловсрол шинжлэх ухаан, гэр бүл, хүүхдийн асуудал), 9.6 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ, 8.5 хувь нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар, 6.5 хувь нь нийгмийн халамж үйлчилгээний мэдээлэл хамгийн их хэрэгцээтэй гэж хариулсан байна.

ЗУРАГ 14. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ХАМГИЙН ИХ ХЭРЭГЦЭЭТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар



Судалгааны дүнгээс харахад бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдэд бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой, өдөр тутмын, хууль эрх зүйн талаар болон нөхөн сэргээлт, байгаль орчны асуудлын талаарх мэдээлэл түлхүү хэрэгцээтэй байна.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдээс мэдээлэл авдаг эх сурвалжийг асуухад 32.4 хувь нь телевизээс, 21.4 хувь нь интернэт нийгмийн сүлжээнээс, 17.0 хувь нь бусад иргэдээс, 15.5 хувь нь гар утсаараа дамжуулан, 6.3 хувь нь хурал, цуглаанаас, 3.0 хувь нь радиогоос, 1.9 хувь нь сонин сэтгүүлээс, 1.3 хувь нь мэдээллийн самбараас, 1.1 хувь нь хэвлэмэл тараах материалаас тус тус мэдээлэл авдаг байна.

ХҮСНЭГТ 17. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ, давхардсан тоогоор, бүсээр, дүнд эзлэх хувиар

Бүс	БҮГД	Мэдээллийн суваг								
		Телевизээс	Радиогоос	Интернет, нийгмийн сүлжээнээс	Гар утсаараа дамжуулан	Бусад иргэдээс	Мэдээллийн самбараас	Сонин, сэтгүүлээс	Хэвлэмэл тараах материалаас	Хурал, цуглаанаас
БҮГД	100.0	32.4	3.0	21.4	15.5	17.0	1.3	1.9	1.1	6.3
Баруун	100.0	34.2	3.6	20.2	14.4	15.8	1.1	1.8	0.7	8.2
Хангайн	100.0	35.0	0.9	19.0	13.2	13.8	3.9	2.4	3.8	8.1
Төвийн	100.0	29.1	3.3	25.3	17.5	19.0	0.7	2.2	0.8	2.2
Зүүн	100.0	31.7	0.9	15.8	17.2	22.0	-	1.1	0.7	10.6

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хамгийн гол мэдээллийн суваг нь бүх бүсийн хувьд телевиз болон интернэт, нийгмийн сүлжээ байна.

ХҮСНЭГТ 18. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ, ДАВХАРДСАН ТООГООР, НАСНЫ БҮЛГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР

Насны бүлэг	Бүгд									
		Телевизээс	Радиоогоос	Интернет, нийгмийн сүлжээ	Гар утсаараа дамжуулан	Бусад иргэдээс	Мэдээллийн самбараас	Сонин, сэтгүүлээс	Хэвлэмэл тараах материал	Хурал, цуглаанаас
БҮГД	100.0	32.4	3.0	21.4	15.5	17.0	1.3	1.9	1.1	6.3
18-19	100.0	26.9	-	40.4	17.3	9.6	1.9	1.9	-	1.9
20-24	100.0	30.6	2.4	31.4	16.6	12.3	0.3	2.4	-	4.0
25-29	100.0	29.1	1.8	27.7	18.5	12.3	1.6	1.6	0.6	6.7
30-34	100.0	31.3	2.9	24.5	16.3	14.8	1.5	1.7	1.8	5.2
35-39	100.0	31.3	3.4	22.6	15.7	16.1	1.1	1.8	1.2	6.9
40-44	100.0	32.0	2.9	21.7	15.4	17.3	1.3	1.6	1.2	6.6
45-49	100.0	32.9	2.8	19.1	15.4	18.6	1.3	2.0	0.9	6.9
50-54	100.0	36.3	3.3	15.2	13.7	21.0	1.1	1.9	1.4	6.0
55-59	100.0	36.3	3.0	14.0	12.7	21.1	1.5	2.8	1.1	7.5
60-64	100.0	35.2	6.0	11.6	13.4	21.3	0.9	4.2	0.9	6.5
65+	100.0	34.4	4.9	18.0	11.5	18.0	1.6	3.3	-	8.2

Насны бүлгээр нь авч үзвэл, 40-өөс дээш насныхан ихэвчлэн телевиз болон бусад иргэдээс мэдээлэл авдаг бол 18-24 насныхан интернэт, нийгмийн сүлжээ болон телевизээр, 30-39 насныхан телевиз болон интернэт, нийгмийн сүлжээгээр дамжуулан хамгийн их мэдээлэл олж авдаг байна.

ХҮСНЭГТ 19. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ АВДАГ СУВАГ, ДАВХАРДСАН ТООГООР, АШИГТ МАЛТМАЛЫН ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР

Ашигт малтмалын төрөл	БҮГД									
		Телевизээс	Радиоогоос	Интернет, нийгмийн сүлжээнээс	Гар утсаараа дамжуулан	Бусад иргэдээс	Мэдээллийн самбараас	Сонин, сэтгүүлээс	Хэвлэмэл тараах материал	Хурал, цуглаанаас
БҮГД	100.0	32.4	3.2	21.7	15.5	16.8	1.2	1.9	1.1	6.2
Алт	100.0	32.6	2.6	21.5	15.2	17.0	1.3	2.0	1.2	6.5
Нүүрс	100.0	22.2	5.6	27.8	11.1	25.0	2.8	2.8	2.8	-
Жонш	100.0	30.1	0.7	24.2	19.0	17.4	0.2	0.7	1.0	6.8
Гянтболд	100.0	21.9	34.4	-	3.1	3.1	-	6.3	-	31.2
Шохойн чулуу	100.0	31.4	17.1	17.1	11.4	8.6	2.9	2.9	-	8.6
Элс, хайрга	100.0	23.8	15.9	26.6	22.0	5.6	-	0.5	0.5	5.1
Давс	100.0	41.1	1.0	13.7	13.0	23.1	3.0	3.7	-	1.3
Улаан чулуу	100.0	32.4	13.5	37.8	5.4	10.8	-	-	-	-
Өнгөт чулуу	100.0	39.1	8.7	26.1	10.9	13.0	-	2.2	-	-
Бусад	100.0	30.2	12.1	24.2	18.8	12.1	-	0.7	-	2.0

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн олборлож буй ашигт малтмалын төрлөөс хамааран мэдээлэл авах суваг нь өөр өөр байна. Алт, нүүрс, жонш, шохойн чулуу, элс, хайрга, улаан болон өнгөт чулуу, бусад ашигт малтмал олборлогчид ихэвчлэн телевиз болон интернэт, нийгмийн сүлжээнээс мэдээлэл авдан бол гянтболд олборлогчид телевиз болон радиогоос, давс олборлогчид телевиз болон бусад иргэдээс ихэвчлэн мэдээлэл авдаг байна.

**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЛЭГ**



V.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хангаагүй, энэ талаарх мэдлэг багатайгаас үүдэн осол аваарт өртөх тохиолдол гардаг.

Бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийн түвшинг асуухад 21.5 хувь нь хангалттай, 66.2 хувь нь зохих хэмжээний, 12.3 хувь нь хангалтгүй гэж хариулсан байна.


ХҮСНЭГТ 20. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, бүсээр, дүнд эзлэх хувиар

Бүс	БҮГД	Хангалттай		
		Хангалттай	Боломжийн	Хангалтгүй
БҮГД	100.0	21.5	66.2	12.3
Баруун	100.0	19.2	70.1	10.6
Хангайн	100.0	24.0	57.2	18.8
Төвийн	100.0	21.9	64.5	13.6
Зүүн	100.0	29.0	66.9	4.1

V.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛДВЭРИЙН ОСОЛ АВААР, ӨВЧНИЙ ТӨРӨЛ

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн 99.1 хувь нь үйл ажиллагаа эрхлэх явцдаа осол, аваарт өртөж байгаагүй гэж хариулсан бол үлдсэн 0.9 хувь нь ямар нэгэн осол, аваарт өртсөн гэж хариулжээ.


ЗУРАГ 15. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨРТӨЖ БАЙСАН ОСОЛ, АВААРЫН ТӨРӨЛ, дүнд эзлэх хувиар



Осол, аварт өртсөн иргэдийн (давхардсан тоогоор) 47.1 хувь нь биет эрхтний гэмтэл авах, 23.5 хувь нь нүхэнд унах, 14.7 хувь нь шороонд дарагдах, 6.0 хувь нь техникийн буруу ашиглалтаас үүсэн гэмтэл авах, 2.9 хувь нь агааргүйдэх, 2.9 хувь нь хөлдөх, 2.9 хувь нь химийн бусад бодисонд хордох осолд өртсөн байна.

Бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэн учирсан хохирлын 84.4 хувь нь эрүүл мэндийн (гэмтэж бэртсэн), 15.6 хувь нь техник, эд материалын хохирол эзэлж байна.

ЗУРАГ 16. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДЭД УЧИРСАН ХОХИРЛЫН ТӨРӨЛ, дүнд эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн 92.8 хувь нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа ямар нэгэн өвчин, эмгэг тусч байгаагүй, 5.0 хувь нь өвчин, эмгэг туссан, 2.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өвчин, эмгэг туссан иргэдийн 41.9 хувь нь ууц нурууны өвчин, 21.0 хувь нь амьсгалын тогтолцооны өвчин, 10.5 хувь нь хоол боловсруулах замын өвчин, 7.7 хувь нь зүрх, судасны тогтолцооны өвчин, 4.4 хувь нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 3.6 хувь нь мэдрэлийн тогтолцооны өвчин, 3.2 хувь нь яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин, үлдсэн 7.7 хувь нь бусад төрлийн өвчнөөр өвчилсөн байна.

ЗУРАГ 17. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛТ, өвчний төрлөөр, дүнд эзлэх хувиар



Бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь үйл ажиллагаа явуулж буй орчин, нөхцлөөс хамаарч ууц нурууны болон амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчилдөг байна.

ХҮСНЭГТ 21. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛ, төрлөөр, ажилласан хугацаагаар, дүнд эзлэх хувиар

Өвчний төрөл	БҮГД	Ажилласан жил						
		0-1	2-3	4-5	6-7	8-9	10-11	12+
Амьсгалын тогтолцооны	100.0	17.3	3.8	13.5	3.8	13.5	23.1	25.0
Ууц нурууны	100.0	19.2	16.3	14.4	7.7	8.7	10.6	23.1
Хоол боловсруулах замын	100.0	19.2	26.9	11.5	7.7	11.5	3.8	19.2
Зүрх судасны тогтолцооны	100.0	26.3	10.5	-	15.8	15.8	10.5	21.1
Арьс ба арьсан доорх ислэгийн	100.0	-	-	100.0	-	-	-	-
Яс, булчингийн тогтолцоо ба холбох эдийн	100.0	25.0	12.5	12.5	25.0	-	-	25.0
Шээс, бэлгийн тогтолцооны эмгэгийн	100.0	-	18.2	-	9.1	9.1	36.4	27.3
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн	100.0	33.3	-	-	-	-	33.3	33.3
Мэдрэлийн тогтолцооны	100.0	33.3	33.3	-	-	11.1	22.2	-
Халдварт ба шимэгчид зарим өвчнөөр	-	-	-	-	-	-	-	-
Бусад	100.0	9.1	27.3	9.1	-	9.1	27.3	18.2

Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өвчилж байсан өвчний төрлийг бичил уурхайд ажилласан жилээр нь авч үзэхэд ууц нурууны өвчнөөр өвчлөгчдийн 23.1 хувь нь 12 ба түүнээс дээш жил, 19.2 хувь нь 0-1 жил, 16.3 хувь нь 2-3 жил, 14.4 хувь нь 4-5 жил, 10.6 хувь нь 10-11 жил, 8.7 хувь нь 8-9 жил, 7.7 хувь нь 6-7 жил ажилласан иргэд байна.

Амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчлөгчдийн 25.0 хувь нь 12 ба түүнээс дээш жил, 23.1 хувь нь 10-11 жил, 17.3 хувь нь 0-1 жил, 13.5 хувь нь 8-9 жил, 13.5 хувь нь 4-5 жил, 3.8 хувь нь 6-7 жил, 3.8 хувь нь 2-3 жил ажилласан иргэд байна.

Хоол боловсруулах замын өвчнөөр өвчлөгчдийн 26.9 хувь нь 2-3 жил, 19.2 хувь нь 12 ба түүнээс дээш жил, 19.2 хувь нь 0-1 жил, 11.5 хувь нь 8-9 жил, 11.5 хувь нь 4-5 жил, 7.7 хувь нь 6-7 жил, 3.8 хувь нь 10-11 жил ажилласан иргэд байна.

ХҮСНЭГТ 22. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛТ, өвчний төрлөөр, бүсээр, дүнд эзлэх хувиар

Өвчний төрөл	БҮГД	Бүс			
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн
Амьсгалын тогтолцооны	100.0	51.9	15.4	17.3	15.4
Ууц нурууны	100.0	44.2	9.6	33.7	12.5
Хоол боловсруулах замын	100.0	23.1	15.4	26.9	34.6
Зүрх судасны тогтолцооны	100.0	36.8	5.3	21.1	36.8
Арьс ба арьсан доорх ислэгийн	100.0	100.0	-	-	-
Яс, булчингийн тогтолцоо ба холбох эдийн	100.0	37.5	12.5	37.5	12.5

Өвчний төрөл	БҮГД				
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн
Шээс, бэлгийн тогтолцооны эмгэгийн	100.0	90.9	-	9.1	-
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн	100.0	50.0	-	50.0	-
Мэдрэлийн тогтолцооны	100.0	33.3	-	-	66.7
Бусад	100.0	63.6	9.1	27.3	-

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үндсэн болон туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн 1057 буюу 30.9 хувь нь үйл ажиллагаа эрхэлж буй сум, дүүргийнхээ эмнэлгээс тусламж авах боломжтой гэж хариулжээ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хамгийн хол зайтай эмнэлэг 750 километр, хамгийн ойр зайтай эмнэлэг 0.2 километр байрлаж байна. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй орд, газраас эмнэлэг хүрэх дундаж зай улсын хэмжээнд 49.9 км байна.

ХҮСНЭГТ 23.. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ СУМ, ДҮҮРГИЙН ЭМНЭЛГИЙН ЗАЙ, километрээр

Бүс, аймаг, нийслэл	Хамгийн ойр зай /километр/	Хамгийн хол зай /километр/	Дундаж зай /километр/
Улсын дундаж	0.2	750.0	49.9
Баруун бүс	0.2	450.0	44.6
Баян-Өлгий	0.2	70.0	6.1
Говь-Алтай	2.0	81.0	24.7
Завхан	15.0	182.0	57.2
Увс	2.0	150.0	55.6
Ховд	8.0	450.0	79.7
Хангайн бүс	4.0	750.0	56.0
Архангай	70.0	750.0	82.9
Баянхонгор	4.0	150.0	39.2
Булган	25.0	85.0	57.5
Орхон	10.0	300.0	57.7
Өвөрхангай	13.0	50.0	29.8
Хөвсгөл	4.0	130.0	69.3
Төвийн бүс	1.0	300.0	38.6
Дархан	3.0	30.0	12.9
Дорноговь	5.0	80.0	31.9
Дундговь	2.0	147.0	40.1
Өмнөговь	10.0	300.0	68.2
Сэлэнгэ	1.0	150.0	37.1
Төв	2.0	100.0	41.9
Зүүн бүс	1.0	150.0	64.8
Дорнод	30.0	100.0	76.4
Хэнтий	1.0	150.0	53.1

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж иргэдийн үйл ажиллагаа явуулж байгаа газраас тухайн сум дүүргийн эмнэлэг орох зайг бүсийн түвшинд авч үзвэл, Баруун бүсийн хувьд хамгийн

хол байрладаг эмнэлэг нь Ховд аймагт (450 км) байдаг бол хамгийн ойр нь Баян-Өлгий аймагт (0.2 км) байдаг байна. Харин Хангайн бүсийн хувьд хамгийн хол байрладаг эмнэлэг нь Архангай аймагт (750 км), хамгийн ойр нь (4 км) Баянхонгор, Хөвсгөл аймагт байна. Төвийн бүсийн хувьд хамгийн хол байрладаг эмнэлэг нь Өмнөговь аймагт (300 км) байдаг бол хамгийн ойр нь Сэлэнгэ аймагт (1 км) байна. Зүүн бүсийн хувьд хамгийн хол байрладаг эмнэлэг нь Хэнтий аймагт (150 км) байдаг бол хамгийн ойр нь мөн л тус аймагт (1 км) байна.

**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

The logo consists of a solid blue square containing the white letters 'VI' in a bold, sans-serif font.

VI

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоног төхөөрөмжийн төрөл, эзэмшил, ашиглалт, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг энэ бүлэгт авч үзсэн.

VI.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА АШИГЛАЖ БУЙ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 85.2 хувь нь ямар нэгэн багаж, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашигладаг байна. Ашиглаж буй нийт тоног төхөөрөмжийн 55.0 хувь нь өөрийн эзэмшлийнх, 42.2 хувь нь хамтын эзэмшлийнх, 2.7 хувь нь түрээсийнх байна.

Тоног төхөөрөмжийн эзэмшлийн хэлбэрийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж 1.3 нэгж хувиар, түрээсийн тоног төхөөрөмж 1.2 нэгж хувиар буурч, харин хамтын эзэмшлийнх 2.5 нэгж хувиар өсжээ.

ЗУРАГ 18. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, эзэмшлийн төрлөөр, дүнд эзлэх хувиар



ХҮСНЭГТ 24.. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, судалгаа явагдсан оноор

Тоног төхөөрөмжийн төрөл	Тоног төхөөрөмжийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2012	2016	2021	2012	2016	2021
Бүгд	34 155	26 268	17 349	100.0	100.0	100.0
Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	22 354	13 606	7 822	65.4	51.8	45.1
Металл хайх төхөөрөмж	1 265	1 458	1 213	4.0	5.5	7.0
Цахилгаан үүсгүүр	1 375	1 950	1 254	4.0	7.4	7.2
Агааржуулагч	694	559	568	2.0	2.1	3.3
Цохилтод өрөм (молоток)	2 147	2 126	1 502	6.3	8.1	8.7
Өргөх төхөөрөмж (лебедка)	1 345	1 065	688	4.0	4.1	4.0
Тороос	-	-	915	-	-	5.2
Усан буу (скруббер)	694	1 051	551	2.0	4.0	3.1
Насос	986	501	606	2.9	1.9	3.5
Бага оврын цохилтод өрөм (компрессор)	697	567	521	2.0	2.2	3.0
Бусад	2 598	3 385	1 709	8.0	12.9	9.9

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн 45.1 хувийг гар багаж (алх, хүрз, жоотуу), 9.9 хувийг бусад төрлийн (шлюз, хуурай алт угаах төхөөрөмж болон бусад) тоног төхөөрөмж, 8.7 хувийг цохилтод өрөм, 7.2 хувийг цахилгаан үүсгүүр, 7.0 хувийг металл хайх төхөөрөмж, 5.2 хувийг тороос, 4.0 хувийг өргөх төхөөрөмж, 3.5 хувийг насос, 3.3 хувийг агааржуулагч, 3.1 хувийг усан буу, 3.0 хувийг бага оврын цохилтод өрөм тус тус эзэлж байна.

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад насос 1.6 нэгж хувиар, металл хайх төхөөрөмжийнх 1.5 нэгж хувиар, агааржуулагч 1.2 нэгж хувиар, бага оврын цохилтод өрөм, өргөх төхөөрөмжийнх 0.8 нэгж хувиар, цохилтод өрөмнийх 0.6 нэгж хувиар өсөж, гар багаж 6.7 нэгж хувиар, усан буу (скруббер) 0.8 нэгж хувиар, цахилгаан үүсгүүр 0.2 нэгж хувиар, өргөх төхөөрөмж (лебедка) 0.1 нэгж хувиар, бусад төрлийн тоног төхөөрөмж 3.0 нэгж хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 25.. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АШИГТ МАЛТМАЛЫН ТӨРЛӨӨР, ДАВХАРДСАН ТООГООР

Ашигт малтмалын төрөл	Бүгд											
		Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	Металл хайгч төхөөрөмж	Цахилгаан үүсгүүр	Агааржуулагч	Цохилтод өрөм (молоток)	Өргөх төхөөрөмж (лебедка)	Тороос	Усан буу (скруббер)	Насос	Бага оврын цохилтод өрөм (комплекс)	Бусад
Бүгд	17 799	8 027	1 247	1 284	590	1 528	695	953	551	623	543	1 758
Алт	14 530	6 228	1 195	1 121	522	1 315	578	715	551	561	414	1 330
Нүүрс	121	55		4	3	13	4	12		8	6	16
Жонш	1 436	815	4	77	31	166	104	114		16	66	43
Гянтболд	11	11										
Шохойн чулуу	61	44						5		3		9
Элс, хайрга	399	229	2	7		1	2	33		12		113
Давс	739	400	16	46	14	8		33		3	35	184
Улаан чулуу	144	43	18	17	11	15	4	8		7	13	8
Өнгөт чулуу	100	27	12	12	9	10	3	7		4	9	7
Бусад	258	175						26		9		48

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн олборлож буй ашигт малтмалдаа ашиглаж буй тоног төхөөрөмжийг төрлөөр нь авч үзвэл, алтны 45.1 хувь, нүүрсний 42.9 хувь, жоншний 56.8 хувь, шохойн чулууны 72.1 хувь, элс хайрганы 57.4 хувь, улаан чулууны 29.9 хувь, өнгөт чулууны 27.0 хувь, бусад ашигт малтмал олборлолтод ашиглаж буй багажны 67.8 хувь нь гар багаж байна. Мөн хамгийн олон тоног төхөөрөмж ашиглаж буй алт олборлогчдын хувьд гар багажнаас гадна цохилтод өрөм, метал хайгч төхөөрөмж, цахилгаан үүсгүүр зэргийг түлхүү ашиглажээ.

ХҮСНЭГТ 26. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, төрлөөр, бүсээр, дүнд эзлэх хувиар

Тоног төхөөрөмжийн төрөл	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	47.9	43.4	40.1	56.0
Металл хайх төхөөрөмж	9.2	3.2	7.0	0.4
Цахилгаан үүсгүүр	7.4	7.2	7.5	5.3
Агааржуулагч	2.4	3.8	4.3	2.1
Цохилтод өрөм (молоток)	8.4	6.2	9.3	10.9
Өргөх төхөөрөмж (лебедка)	2.7	4.8	4.4	7.5
Тороос	3.9	5.0	6.3	8.1
Усан буу (скруббер)	1.7	5.1	4.9	0.4
Насос	1.9	4.6	5.4	1.3
Бага оврын цохилтод өрөм (компрессор)	1.8	3.0	4.0	4.7
Бусад	12.6	13.7	6.8	3.5

VI.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 2686 (78.5%) нь ямар нэгэн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байна.

ХҮСНЭГТ 27. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, хүйсээр

Хүйс	БҮГД		Тийм		Үгүй	
	2016	2021	2016	2021	2016	2021
	БҮГД	5 998	3 423	4 330	2 686	1 668
Эрэгтэй	5 206	2 730	3 838	2 137	1 368	593
Эмэгтэй	792	693	492	549	300	144

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэж байгаа бичил уурхайн олборлогчдын эзлэх хувь 6.3 нэгж хувиар өсжээ.

Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг уул уурхай олборлогчдыг насны бүлгээр нь авч үзвэл, 40-44 насныхан 17.9 хувийг, 35-39 насныхан 16.5 хувийг, 45-49 насныхан 14.6 хувийг, 30-34 насныхан 14.4 хувийг, 50-54 насныхан 11.6 хувийг, 25-29 насныхан 9.2 хувийг, 15.7 хувийг бусад насныхан эзэлж байна.


ХҮСНЭГТ 28. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭДЭГ ЭСЭХ, НАСНЫ БҮЛГЭЭР

Насны бүлэг	БҮГД		Тийм		Үгүй	
	2016	2021	2016	2021	2016	2021
БҮГД	5 998	3 423	4 330	2 686	1 668	737
10-14	1	-	-	-	1	-
15-17	10	-	7	-	3	-
18-19	62	28	45	17	17	11
20-24	376	182	249	125	127	57
25-29	863	296	610	247	253	49
30-34	983	493	721	388	262	105
35-39	987	566	724	442	263	124
40-44	964	610	697	481	267	129
45-49	787	505	593	393	194	112
50-54	586	388	431	312	155	76
55-59	260	234	169	190	91	44
60-64	91	96	60	71	31	25
65-69	23	24	20	19	3	5
70 +	5	1	4	1	1	-

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 18-19, 65-69 насны бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хөдөлмөр хамгааллын хувцасны хэрэглээний эзлэх хувь буурч, бусад насны иргэдийн хувьд өссөн байна.

Хөдөлмөр хамгааллын хувцасны хэрэглээг боловсролын түвшингээр харахад боловсролгүй иргэдийн 3.8 хувь нь, бага болон суурь боловсролтой иргэдийн 25.9 хувь нь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 47.5 хувь нь, техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой иргэдийн 13.3 хувь нь, дээд боловсролтой иргэдийн 9.5 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байна.

ЗУРАГ 19. ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭДЭГ БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 31.0 хувь нь каск, 43.9 хувь нь гутал, 57.6 хувь нь маск, 29.0 хувь нь хантааз, 71.5 хувь нь бээлий, 38.3 хувь нь нүдний шил, 18.6 хувь нь чихэвч, 48.0 хувь нь гэрэл хэрэглэдэг байна.

ХҮСНЭГТ 29. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ХЭРЭГЛЭДЭГ ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, төрлөөр, бүсээр, хувиар

Бүс	Каск	Гутал	Маск	Хантааз	Бээлий	Нүдний шил	Чихэвч	Гэрэл
БҮГД	31.0	43.9	57.6	29.0	71.5	38.3	18.6	48.0
Баруун	21.6	30.7	66.4	22.0	79.7	36.6	15.8	52.5
Хангайн	48.7	40.7	44.7	35.5	65.9	36.2	24.9	47.3
Төвийн	30.5	54.5	48.0	31.8	62.0	39.4	19.5	44.8
Зүүн	59.6	74.3	76.3	46.5	80.0	46.5	19.2	38.8

Өмнөх судалгааны дүнгээр нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 72.2 хувь нь ямар нэгэн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байсан бол 2021 онд 78.5 хувь болжээ. Гянтболд олборлогчдын 90.9 хувь, жонш олборлогчдын 84.8 хувь, алт олборлогчдын 78.7 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг болсон нь өмнөх судалгааны дүнгээс гянтболд олборлогчдын хөдөлмөр хамгааллын хувцасны хэрэглээний эзлэх хувь 18.9 нэгж хувиар, алт олборлогчдынх 3.1 нэгж хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 20. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭДЭГ ЭСЭХ, ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар



**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ**



БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаа, тэдний олборлож буй ашигт малтмалын хэмжээ, орлого, зардал, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар энэ бүлэгт авч үзлээ.

VII.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн эрхлэгчдийн давхардсан тоогоор 2875 нь алт, 284 нь жонш, 127 нь давс, 66 нь элс, хайрга, 22 нь өнгөт чулуу, 16 нь улаан чулуу, 12 нь нүүрс, 12 нь шохойн чулуу, 11 нь гянтболд, 58 нь бусад төрлийн ашигт малтмал олборлож байна.

ХҮСНЭГТ 30. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ашигт малтмалын төрлөөр, бүсээр

Бүс	БҮГД										
		Алт	Нүүрс	Жонш	Гянтболд	Шохойн чулуу	Элс хайрга	Давс	Улаан чулуу	Өнгөт чулуу	Бусад
Бүгд	3 483	2 875	12	284	11	12	66	127	16	22	58
Баруун	1 513	1 311	2	1	11	7	47	104	-	-	30
Хангайн	425	383	7	-	-	-	6	1	-	-	28
Төвийн	1 300	1 121	3	121	-	-	13	4	16	22	-
Зүүн	245	60	-	162	-	5	-	18	-	-	-

Нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн давхардсан тоогоор 76.8 хувь нь ил хэлбэрийн орд газарт олборлолт явуулж байгаа бол 23.2 хувь нь далд хэлбэрийн орд газарт олборлолт явуулж байна.

ХҮСНЭГТ 31. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, орд газар, ашигт малтмалын төрлөөр, дүнд эзлэх хувиар

Ашигт малтмалын төрөл	БҮГД		
		Ил орд	Далд орд
БҮГД	100.0	76.8	23.2
Алт	100.0	75.2	24.8
Нүүрс	100.0	100.0	-
Жонш	100.0	78.2	21.8
Гянтболд	100.0	90.9	9.1
Шохойн чулуу	100.0	58.3	41.7
Элс хайрга	100.0	100.0	-
Давс	100.0	100.0	-
Улаан чулуу	100.0	-	100.0
Өнгөт чулуу	100.0	45.5	54.5
Бусад	100.0	100.0	-

Алт олборлогчдын 75.2 хувь нь, жонш олборлогчдын 78.2 хувь нь, гянтболд олборлогчдын 90.9 хувь нь, шохойн чулуу олборлогчдын 58.3 хувь нь, өнгөт чулуу олборлогчдын 45.5 хувь нь ил хэлбэрийн орд газарт үйл ажиллагаа явуулж байна. Нүүрс, элс, хайрга, давс олборлогч иргэд 100.0 хувь ил хэлбэрийн орд газарт үйл ажиллагаа явуулж байна.

VII.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТАЛБАЙ

Судалгааны хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 855 (26.3%) нь зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа эрхэлж байна.

ХҮСНЭГТ 32. БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ашиглаж буй талбайн төрлөөр, бүсээр

Бүс	БҮГД			Зөвшөөрөлгүй талбайд ажиллаж байгаа хүний тоо			Зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа хүний тоо		
	2012	2016	2021	2012	2016	2021	2012	2016	2021
БҮГД	7 273	5 998	3 254	5 625	4 935	2 399	1 648	1 063	855
Баруун	1 982	2 527	1 469	1 523	2 139	1 193	459	388	276
Хангайн	2 183	935	420	1 936	731	216	247	204	204
Төвийн	2 236	2 202	1 230	1 914	1 886	958	322	316	272
Зүүн	251	164	135	163	98	32	88	66	103
Улаанбаатар	621	170	-	89	81	-	532	89	-

Зөвшөөрөлтэй талбайд үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхайн үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүсээр авч үзвэл, 276 (32.3%) нь Баруун бүсэд, 204 (23.9%) нь Хангайн бүсэд, 272 (31.8%) нь Төвийн бүсэд, 103 (12.0%) нь Зүүн бүсэд ногдож байна.

Нийт зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа бичил уурхай эрхлэгчдийн 61.2 хувь нь алт олборлогчид, 16.4 хувь нь жонш, 11.6 хувь нь давс, 4.6 хувь нь элс хайрга, үлдсэн хувь нь бусад ашигт малтмал олборлогчид байна.

ХҮСНЭГТ 33. ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД АЖИЛЛАЖ БАЙГАА БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД, ашигт малтмалын төрөл, ашиглаж байгаа талбайн төрлөөр, давхардсан тоогоор

Ашигт малтмалын төрөл	БҮГД			Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар			Аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар			Бусад		
	2012	2016	2021	2012	2016	2021	2012	2016	2021	2012	2016	2021
БҮГД	1 648	1 063	882	692	650	596	930	373	265	26	40	21
Алт	744	731	540	480	442	351	261	262	185	3	27	4
Нүүрс	543	30	5	33	1	2	493	24	3	17	5	-
Жонш	176	195	145	150	155	80	20	39	62	6	1	3
Гянтболд	153	57	3	3	30	1	150	26	2	-	1	-
Шохойн чулуу	-	14	6	-	12	6	-	2	-	-	-	-
Элс хайрга	12	3	41	12	2	38	-	-	3	-	1	-
Давс	-	-	102	-	-	92	-	-	10	-	-	-
Бусад	20	33	40	14	8	26	6	20	-	-	5	14


Алт олборлогчдын ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 65.0 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, 34.3 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, 0.7 хувь нь

бусад төрлийн зөвшөөрөлтэй байна. Харин нүүрс олборлогчдын ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 60.0 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, 40.0 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газрын зөвшөөрөлтэй байна.

Жонш олборлогчдын ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 55.2 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, 42.8 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, 2.1 хувь нь бусад төрлийн зөвшөөрөлтэй, харин гянтболд олборлогчдын ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 33.3 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, 66.7 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар байна.

Судалгаанд хамрагдсан иргэд бичил уурхайн зориулалтаар 702.1 га талбайг ашиглаж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2016 оныхоос 81.0 хувиар, 2012 оныхоос 91.6 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 21. АШИГЛАСАН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, судалгаа явагдсан оноор



Бичил уурхайн зориулалтаар ашиглаж байгаа талбайн 24.6 хувь нь Баруун бүсэд, 116.0 га 16.5 хувь нь Хангайн бүсэд, 48.7 хувь нь Төвийн бүсэд, 10.1 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

Судалгааны дүнгээр бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч иргэд 119.1 га талбайд нөхөн нөхөн сэргээлт хийсэн байна. Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг бүсээр авч үзвэл, 19.1 хувь нь Баруун бүсэд, 34.8 хувь нь Хангайн бүсэд, 30.5 хувь нь Төвийн бүсэд, 15.7 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 34. БИЧИЛ УУРХАЙД АШИГЛАЖ БУЙ ТАЛБАЙ, НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, бүсээр

Бүс	Ашиглаж байгаа талбайн хэмжээ, га			Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, га		
	2012	2016	2021	2012	2016	2021
БҮГД	8 319.3	3 701.7	702.1	594.3	382.8	119.1
Баруун	2 871.3	499.5	173.0	78.6	220.7	22.7
Хангайн	1 584.8	924.7	116.0	146.9	55.2	41.4
Төвийн	2 113.2	1 276.3	342.1	4.3	102.4	36.3
Зүүн	558.9	110.4	71.0	356.5	4.2	18.7
Улаанбаатар	1 191.0	890.8	-	8.0	0.3	-

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид 113.2 кг алт, 1.3 мянган тонн нүүрс, 9.1 мянган тонн жонш, 6.5 тонн гянтболд, 152.4 тонн шохойн чулуу, 25.3 мянган тонн

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

элс хайрга, 2.0 мянган тонн давс, 3.1 тонн улаан чулуу, 11.3 тонн өнгөт чулуу олборложээ. Олборлосон ашигт малтмалын хэмжээг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад шохойн чулуу 82.6 тонн (2.2 дахин их)-оор, элс хайрга 23.6 мянган тонн (15.6 дахин их)- оор тус тус өссөн бол харин алт 98.8 кг (46.6%), нүүрс 157.7 мянган тонн (99.2%) хувь, жонш 11.7 мянган тонн (56.4%), гянтболд 154.6 тонн (96.0%) хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 35. БОРЛУУЛСАН АШИГТ МАЛТМАЛЫН ХЭМЖЭЭ, ашигт малтмалын төрлөөр

Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2012	2016	2021
Алт	кг	354.6	212.0	113.2
Нүүрс	тонн	141 970.6	159 025.4	1 306.6
Жонш	тонн	38482.7	20 818.3	9 086.3
Гянтболд	тонн	108.3	161.1	6.5
Шохойн чулуу	тонн	66.6	69.8	152.4
Элс хайрга,	тонн	-	1 616.0	25 250.8
Давс	тонн	1062.3	-	1 982.8
Улаан чулуу	тонн	-	-	3.1
Өнгөт чулуу	тонн	-	-	11.3
Үнэт чулуу	тонн	14.7	27.3	-

